

**“ХУВИЙН ТЭТГЭВРИЙН ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСӨЛД
“ТЭТГЭВРИЙН УУГАН САН” ТББ –ИЙН ЗҮГЭЭС ӨГӨХ САНАЛУУД:**

**НЭГ. ХУВИЙН ТЭТГЭВРИЙН САНГИЙН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧДЫН ТАЛААР:
(Хуулийн төслийн 11,12-р зүйл)**

- 1.1. ХТС-г үүсгэн байгуулагч буюу хувьцаа эзэмшигчид нь ХТС-д хөрөнгө оруулснаар ямар байдлаар ашиг олох нь тодорхойгүй байна. Ашиг олох боломжгүй зүйлд хөрөнгө оруулахаар бол ХТС бүрдэх боломжгүй болно, эсхүл буруу ашиг сонирхолоор хөрөнгө оруулах магадлалтай болно. Иймээс энэ асуудал тодорхой байх хэрэгтэй байна. Нэгэнт ХТС нь компани хэлбэртэй ашгийн төлөө ажиллах хуулийн этгээд байхаар заасан байгаа тул ХТС-ийн захиргааны зардал дотор ашгийн маржин оруулж тооцож болох тухай энэ хуулиар тодорхой зааж өгөх нь зүйтэй гэж үзэж байна. *Энэ талаар доор /Захиргааны зардал хэсэгт/ дэлгэрэнгүй тусгав.*
- 1.2. “11.2. Хувийн тэтгэврийн санг хэд хэдэн этгээд хувь нийлүүлэн үүсгэн байгуулах ба нэг үүсгэн байгуулагчийн эзэмших хувь 10 хувиас ихгүй байна.” гэснийг нэг үүсгэн байгуулагчийн эзэмших хувийг **34 хувиас ихгүй** болгож өөрчлөх. Учир нь олон жижиг хувьцаа эзэмшигчтэй байх нь тухайн тэтгэврийн сангийн үйл ажиллагааг манлайлах эзэнгүй болгож, хариуцлагыг бие биедээ түлхэх сул талтай.
- 1.3. “11.4. Хувийн тэтгэврийн сангийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний доод хэмжээ 100 тэрбум төгрөгөөс багагүй байна. Хувийн тэтгэврийн сангийн тогтвортой байдал, эрхлэх үйл ажиллагааны онцлогийг харгалзан дүрмийн сан болон өөрийн хөрөнгийн зохистой хэмжээг Санхүүгийн зохицуулах хороо тогтооно.” Шинээр үүсч буй ХТС-ийн хувьд хэдийгээр нийт 5 сан байхаар хязгаарлаж байгаа хэдий ч энд заасан 100 тэрбум төгрөг нь одоогийн нөхцөлд хэтэрхий өндөр дүн гэж үзэж байна. Системийн нөлөө бүхий банкуудын нийт актив ДНБ-тэй ойролцоо байгаа энэ цаг үед дүрмийн сан нь 50 тэрбум төгрөгөөс эхэлж байгаа ба 2022 оноос 100 тэрбум болгож өсгөхөөр тогтоосон байгаа. Шинээр байгуулагдах ХТС-ийн хувьд дүрмийн сангийн хэмжээг эхний ээлжинд **10 тэрбумаас эхлүүлж** хуримтлалын хэмжээтэй уялдуулан өөрийн хөрөнгийн хүрэлцээний хязгаар тогтоон, түүнд захирагдах замаар дүрмийн санг нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна. Мөн дүрмийн сангаас тэтгэврийн хөрөнгөтэй уялдуулан даатгалын байгууллага шиг нөөц хөрөнгийг захиран зарцуулах эрхгүйгээр тусгаарладаг байж болох юм.
- 1.4. “12 дугаар зүйл. Хувийн тэтгэврийн санг үүсгэн байгуулагчид тавих шаардлага”-д үүсгэн байгуулагч нь аливаа улс төрийн ашиг сонирхолоос ангид, улс төрийн нөлөө бүхий этгээд байхыг хориглох, банк, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хувьцаа эзэмшигчид тавьдагтай адил мэргэжлийн шаардлага, шалгуурыг хангасан этгээд байх тухай нэмэх.

ХОЁР. ХУВИЙН ТЭТГЭВРИЙН САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАЛААР:

(Хуулийн төслийн 15, 16-р зүйл)

- 2.1. “15.1.Тэтгэврийн сангийн эрх барих дээд байгууллага нь Удирдах зөвлөл байна.” гэжээ. Энэ тохиолдолд Удирдах зөвлөлийг хэн сонгох, хэн томилох нь тодорхойгүй байна. Удирдах зөвлөлийг ХТС-ийн үүсгэн байгуулагч буюу хувьцаа эзэмшигчид сонгож болох боловч томилгоог заавал мэргэжлийн байгууллагын зөвшөөрлөөр хийж, мэргэжил, туршлага, ёс зүйн хувьд тохиромжтой этгээд байх шаардлагыг хангуулах шаардлагатай.
- 2.2. “15.1.4. Удирдах зөвлөлийн гишүүдийн тоог 5-аас доошгүй байхаар тодорхой зааж өгөх. Мөн удирдах зөвлөлийн 1/3 буюу гуравны нэг хувиас доошгүй нь хараат бус гишүүдээс бүрдсэн байна. гэснийг **хараат бус гишүүд 40-с дээш** хувь болгож мэргэжлийн удирдлага бүрдүүлэх нөхцлийг бий болгох.
- 2.3. “15.1.3.Удирдах зөвлөлийн бүх гишүүд нь Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурт нийцсэн байна; гэснийг тодорхой задалж банк, **хөрөнгө оруулалтын менежментийн компанийн ТУЗ-д** тавьдагтай адил **шалгуурыг тодорхой** болгох хэрэгтэй. ХТС-ийн онцлогоос үүдэн Удирдах зөвлөл нь ХТС-ийн хамгийн чухал баримт бичиг болох хөрөнгө оруулалтын бодлогыг батлах, ХОМК-ийн үйл ажиллагааг үнэлж дүгнэн хяналт тавих мэргэжлийн чадвартай байх хэрэгтэй. Тиймээс дан ганц хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлыг төлөөлөх хүн байх нь хангалтгүй юм. Үүнийг хуульд тодорхой зааж оруулах.
- 2.4. Мөн Хувьцаа эзэмшигч, Удирдах зөвлөлийн гишүүн, ХТС-д ажиллаж байгаа ажилтан, Аудитын хороо зэрэг бүхий л **шууд оролцогчид тухайн ХТС-д тэтгэврийн данстай** байх шаардлага тавих. Эдгээр хүмүүсийн бодит ашиг сонирхол тэтгэврийн данс эзэмшигчдийнхтэй нэг ижил байх хэрэгтэй.
- 2.5. “15.1.5.Удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагаа явуулах журмыг батална.” гэснийг “15.1.5.Удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагаа явуулах журмыг хувьцаа эзэмшигч, хяналтын зөвлөлийн хамтаар хуралдаж олонхийн саналаар батална.” гэж өөрчлөх.

ГУРАВ. ХУВИЙН ТЭТГЭВРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

(Хуулийн төслийн 14-р зүйл болон бусад нэмэлт)

Энэ хуулийн хэрэгжүүлэгчид буюу оролцогчдын үүрэг, хариуцлага, эрхийг хуулийн төсөлд тусгаснаас гадна дараах зүйлсийг тусгаж, нэмэлт, өөрчлөлт оруулах саналтай байна. Үүнд:

Иргэн:

- 3.1. Өөрийн сонгосон хувийн тэтгэврийн сангийн мэдээллийг НДЕГ-т мэдэгддэг байх.
- 3.2. Улсаас хэрэгжүүлдэг албан журмын эсвэл сайн дурын тэтгэврийн даатгалд заавал хамрагдсан байж хувийн тэтгэврийн даатгалд хамрагдах эрх нээгддэг байх.
- 3.3. Өөрийн хамрагддаг хувийн тэтгэврийн сангийн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэрээ дэвшүүлэх эрхтэй, шаардлага хангасан хүн сонгогдох боломжтой байх.

3.4. Өөрийн мэдээллийн нууцлал, хуримтлалын үнэн зөв байдалд хяналт тавих, шаардлага тавих, холбогдох мэдээллээ өөрчлөгдөх бүрт засаж шинэчлэх зэрэг үүргийг тусгах.

Ажил олгогчид:

3.5. Ажилтны аль хувийн тэтгэврийн санг сонгож үйлчлүүлэх нь хамаагүй байх.

3.6. Ажил олгогч ажилтны цалингаас суутгасан, өөрийн нэмж олгож буй НДШ-ийг урьдын адил НДЕГ-т шилжүүлдэг байх.

(Ингэснээр ажилтны цалингаас татсан хувийн тэтгэврийн шимтгэлийг хугацаандаа шилжүүлэхгүй байх, буруу дансанд шилжүүлэх, буруу дүнгээр шилжүүлэх, тэр бүрийг хянах, залруулах, нягтлан бодогч нар ажилтнуудын хувийн тэтгэвэрт хамрагдах боломжийг хязгаарлах, цааргалах зэрэг олон сул байхгүй болно.)

Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар / НДЕГ/ :

3.7. НДЕГ нь ХТС-д хамрагдаж байгаа иргэдэд юун түүрүүнд улсаас хэрэгжүүлдэг албан журмын эсвэл сайн дурын тэтгэврийн даатгалд хамрагдсан байхыг шаарддаг байх.

3.8. Иргэдийн тэтгэврийн дансны бүртгэл, дансны мөнгөн хөрөнгийн оролт гаралтыг дамжуулдаг, хянадаг байх. Дараах байдлаар хийх. Үүнд:

3.8.1. Иргэдээс болон ХТС-аас ирсэн хүсэлтийн дагуу хувийн тэтгэврийн санд хамрагдсан иргэдийн гэрээ, шилжилт хөдөлгөөний мэдээллийг өөрийн мэдээллийн санд бүртгэдэг байх. Ингэхдээ иргэн, ХТС-ийн 2 талын мэдээлэлд үндэслэн баталгаажуулдаг байх.

3.8.2. НДЕГ-нь ХТС-д хамрагдан бүртгэл баталгаажсан иргэдийн хувийн тэтгэврийн сангийн 2%+2% /ажилтан болон ажил олгогчоос орох/ мөнгөн хөрөнгийг хувийн тэтгэврийн санд ажлын 3 хоногт багтаан шилжүүлдэг байх.

3.8.3. НДЕГ-т ХТС-д хамрагдсан иргэдийн хувийн тэтгэврийн дансны бүртгэлийг хадгалдаг, хянадаг байх гомдол саналыг СЗХ-д дамжуулдаг байх.

3.8.4. Иргэний хувийн тэтгэврийн дансанд алдаа гарсан нь нотлогдож засварлах тохиолдолд засварлах зөвшөөрөл, эрхийн хязгаарыг ХТС-д өгдөг байх.

3.8.5. Иргэдэд нийгмийн даатгалын шимтгэл болон түүн дотроо хувийн тэтгэврийн дансны мэдээллээ харах, хянах боломжийг бүрдүүлэх.

3.8.6. Иргэдийг нас барсан тохиолдолд хувийн тэтгэвэртэй холбоотой мэдээлэл, зөвлөмжийг эрх залгамжлагч, эсвэл өвлөгчид өгдөг байх. Эзэндээ очиж байгаа эсэхэд хяналт тавьдаг байх.

3.8.7. Дансны үлдэгдэлтэй боловч иргэнээс шимтгэл орохгүй, тэтгэвэр гарахгүй байгаа данснууд буюу идэвхгүй тэтгэврийн дансанд хяналт тавьж ХТС-тай хамтран ажилладаг байх.

3.9. НДЕГ нь ХТС-д болон иргэдэд дээрх үйлчилгээг үзүүлснийхээ төлөө дээрх ажлуудтай холбогдон гарах зардлыг нөхөх хэмжээд ХТС-ийн тодорхой шимтгэл авдаг байж болох.

Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/:

3.10. Хувийн тэтгэврийн хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, хөрөнгө оруулалтын **баталгаат өгөөж** буюу өгөөжийн доод түвшин буюу индексийг жилд 1 удаа тогтоож зарладаг байх. Индексийг өмнөх оны инфляцийн түвшин, Монгол банкны бодлогын хүүтэй уялдуулах

замаар тэтгэврийн хөрөнгийг урт хугацаанд үнэ цэнийн алдагдлаас хамгаалах хэмжээнд тогтоох.

- 3.11. Эрсдэлийн сан бүрдүүлэх журам, эх үүсвэр, хөрөнгө оруулах боломжит хязгаарыг тодорхойлсон журам гаргах.
- 3.12. Бэлэн мөнгөний дутагдлаас сэргийлэх журам, эх үүсвэрийг тодорхойлох, боломжит хязгаарыг тогтоож өгөх.
- 3.13. ХТС хэт том бүтэцтэй байхыг шаардахгүй, хяналт, бүртгэлийн, бичиг цаасны ажил их байхад хүргэхгүй байх. Урт хугацаанд тогтвортой, найдвартай ажиллуулахад анхаарах.
- 3.14. ХТС-ийн үйл ажиллагаанд оролцогчдын үйл ажиллагаанд давхардал үүсгэхгүйгээр зохион байгуулах.

Хувийн тэтгэврийн сан /ХТС/ :

- 3.15. Хувийн тэтгэврийн сан нь шимтгэл төлөгчдийн хуримтлал НДЕГ-аас үнэн зөв орж ирсэн эсэхэд хяналт тавих эрхтэй байх.
- 3.16. Мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, тэтгэврийн дансны мэдээллийн нууцлалыг хангадаг байх. **Шимтгэл төлөгчийн хуримтлал, нэрийн дансны мэдээлэл нь тухайн иргэний цалин, орлогын мэдээлэл болох тул энэ мэдээллийг ХТС нь зөвхөн НДЕГ – тай тулган баталгаажуулдаг байх.** СЗХ нь ХТС-ийн хөрөнгө оруулалт талын зохицуулалтыг хариуцаж, НДЕГ нь ХТС-ийн шимтгэл төлөгч /гишүүдийн нэрийн данс/цалингийн мэдээллийн зохицуулалтыг хариуцаж байх нь тохиромжтой гэж үзэж байна.
- 3.17. Шимтгэл төлөгчдийн хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалах хөрөнгө оруулалтын өгөөжөөр өсгөх зорилгоор урт хугацааны Эрсдэлийн сан бүрдүүлж ажилладаг байх. ХТС Эрсдэлийн сангийн хөрөнгийн үнэ цэнийг хамгаалах, эрсдэл багатай хөрөнгө оруулалтад оруулж, эрсдлийн сангийн хөрөнгийн үнэ цэнийг хамгаалах хэмжээнд удирдах эрхтэй байх.
- 3.18. Бэлэн мөнгөний дутагдлаас сэргийлсэн хөрөнгө оруулалтын бодлого баримтлах.
- 3.19. ХТС-ууд тэтгэврийн дансанд СЗХ-оос тогтоосон баталгаат өгөөж буюу индексээс доошгүй хэмжээгээр өгөөж хуваарилахыг хичээж ажиллах. **Өгөөж амлахгүй, зарлахгүй байх.** (Өгөөж, тооцох хуваарилахыг доор дэлгэрүүлье).
- 3.20. Хөрөнгийн менежментийг бүхэлд нь ХОМК-оор удирдуулаагүй тохиолдолд удирдуулаагүй хэсэгт хамаарах ХТС-ийн хөрөнгө оруулалтын шийдвэрийг хэн, хэрхэн гаргах, гүйцэтгэх этгээдэд тавигдах шаардлага, эрх, үүргийг тодорхойлох.

ДӨРӨВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖИЙН ТАЛААР: **(Хуулийн төслийн 9-р зүйл)**

Хөрөнгө оруулалтын өгөөжийн хувьд ойлголт, тооцоололт, хуваарилалтыг өөрчлөх саналтай байна. Үүнд:

- 4.1. Хуулийн төсөл заасан **“баталгаат өгөөж”**-ийг утга агуулгын хувьд дараах байдлаар өөрчлөх: - **“баталгаат өгөөж”** гэж хувийн тэтгэврийн сан дахь тэтгэврийн хөрөнгийг санхүүгийн жилд хөрөнгө оруулалтын өгөөжөөр өсгөх СЗХ-оос тогтоосон доод хэмжээг хэлэх.
- 4.2. СЗХ нь хувийн тэтгэврийн хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалах, хөрөнгө оруулалтын **баталгаат өгөөж** буюу өгөөжийн доод түвшин буюу индексийг жилд 1 удаа тогтоож зарладаг байх. Индексийг өмнөх оны инфляцийн түвшин, Монгол банкны бодлогын хүүтэй уялдуулах замаар тэтгэврийн хөрөнгийг урт хугацаанд үнэ цэнийн алдагдлаас хамгаалах хэмжээнд тогтоох
(Улс орнуудын туршилагаар насан туршид олгох буюу тодорхой тэтгэврийн (Defined Benefit) хөтөлбөрийн тухайд тэтгэврийн хуримтлалыг өсгөх доод хэмжээ буюу индексийг (indexation of benefits in payment) төрөөс тогтоож өгсөн байдаг. Энэ индекс буюу баталгаат ашгийг өмнөх оны инфляцийн түвшинээс багагүй эсвэл тогтмол хэмжээгээр тогтоож өгдөг.
- 4.3. ХТС-ууд хөрөнгө оруулалтын өгөөж амлах болон зарлахыг хориглох.
- 4.4. Шимтгэл төлөгч тэтгэврийн сангаас жилийн дундуур нэг удаагийн багц тэтгэвэр, орон сууцны урьдчилгааны зардал, хуваарьт тэтгэвэр, аннютти зэрэг мөнгөн хөрөнгө гаргах бүрт **гарч байгаа мөнгөн хөрөнгөд тухайн жилийн харгалзах хугацаанд ногдох өгөөжийг тухайн жилд мөрдөж буй баталгаат өгөөжийн хэмжээгээр** тооцон нэрийн дансанд бүртгэх.
- 4.5. “9.6.-д зааснаар баталгаат өгөөжид хүрээгүй бол ХТС өөрийн хөрөнгөөр нөхөж олгоно гэсэн байгаа нь ХТС-ийн тогтвортой үйл ажиллагааг алдагдуулахаар байна. Өөрийн хөрөнгөрүү орохоос өмнө эрсдлийн сан бүрдүүлж, эрсдлийн сангаас зөрүүг олгодог байх нь зүйтэй. **Тиймээс эрсдлийн санг бүрдүүлэхдээ хөрөнгө оруулалтын нийт өгөөжөөс тодорхой хувийг эхний ээлжинд эрсдлийн санд бүрдүүлж байх, өгөөжийн түвшин өндөр жилүүдэд өмнөх эрсдлийн сангаас авсан хэсгийг тусад нь нөхөж бүрдүүлдэг байх.** Эрсдлийн сан алдагдалд орох нөхцөл байдал үүсэн үед ХТС өөрийн хөрөнгөөс нэмж бүрдүүлэх, мөн өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлага хангах хэмжээгээр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлдэг байх.
- 4.6. ХТС нь хөрөнгө оруулалтын өгөөжөө сар бүр тооцно. Гэхдээ тэтгэврийн нэрийн дансанд сар бүр хуваарилаж, бүртгэхгүй, харин жилийн эцэст буюу 12.31-ний өдрөөр тэтгэврийн дансанд тухайн жилийн хуваарилвал зохих өгөөжийг тооцож бүрэн хуваарилдаг байх. Энэ өгөөжийг **“бодит өгөөж”** гэж нэрлэж болно. Бодит өгөөж нь баталгаат өгөөжөөс дээш байхаар зорьж ажиллах бөгөөд хэрэв баталгаат өгөөжөөс доош орсон бол баталгаат өгөөжийг хүртэл хэмжээгээр эхлээд эрсдэлийн сангаас, дараа нь өөрийн хөрөнгөөс нөхөж бүрдүүлдэг байх.

4.7. Шимтгэл төлөгчид хуваарилагдах баталгаат өгөөж / бодит өгөөжийг бүрдүүлж байгаа хөрөнгө оруулалтын орлого болох хадгаламжийн хүү, бондын хүү, хувьцаа арилжсаны орлого зэргээс **ашгийн татвар суутгах эсэхийг тодорхой болгож** хэрэв суутгахгүй гэвэл Хувь хүний орлогын албан татварын хуульд нэмж оруулах.

ТАВ. ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫН ТУХАЙ:
(Хуулийн төслийн 16-р зүйл)

Нэр томъёо болон бүртгэлийн хувьд дараах байдлаар өөрчлөх саналтай байна. Үүнд:

5.1. Хуулийн төсөлд заасан **“Захиргааны зардал”** гэдэг ойлголт нь явцуу хүрээнд ойлгогдож байгаа тул “Үйл ажиллагааны зардал” болгон өөрчлөх, мөн энэ зардалд юу юу орохыг тодорхой болгох.

5.2. Шимтгэл төлөгчийн тэтгэврийн хуримтлалд өгөөж тооцож хуваарилахдаа нийт хөрөнгө оруулалтын өгөөжөөс дараах дарааллаар зардал суутгах:

- Эрсдлийн сангийн хураамж
- ХОМК-н авах хувь, / ХОМК нь брокерийн арилжааны зардлыг өөрөө хариуцах, ХОМК үүнийг хариуцах нь үр ашиггүй олон арилжаа хийж зах зээлийн ханшид нөлөөлөх боломжийг хязгаарлана/ болон
- мөн кастодианы төлбөрийг удирдуулж буй хөрөнгийн дүнгээс хувьчилан тооцож
- дээрхийг хассан дүнгээс ХТС-ийн захиргааны зардлыг хасч, үлдэж буй өгөөжийн дүнг шимтгэл төлөгчийн дансанд хуваарилна.

Иймээс ХТС-ийн хувьцаа эзэмшигчдийн хүртэх ашгийг захиргааны зардал дотор тодорхой хэмжээний **ашгийн маржин** байдлаар оруулж тооцохоос өөр аргагүй харагдаж байна.

5.3. ХТС-ийн ашгаас **татвар суутгах эсэхийг** мөн тодорхой болгох.

5.4. “16.2.-т Захиргааны зардал нь тэтгэврийн хөрөнгийн хуримтлалаас тооцох хүү болон хөрөнгө оруулалтын баталгаат өгөөжийн 2 хувиас хэтрэхгүй байна” гэжээ. Энэ хувь хэмжээг дахин тооцох хэрэгтэй. Учир нь хөрөнгө оруулалтын сангийн менежмент, кастодиан банкны үйлчилгээ зэрэг нь нийт хөрөнгийн тодорхой хувиар заагдсан байдаг. Захиргааны зардлыг өгөөжийн тодорхой хэсэгтэй уялдуулж тогтоох нь буруу байна. Өгөөж бага, өгөөжгүй байх зэрэг тохиолдолд өгөөжөөс суутгаж өгөх ХОМК, кастодианы төлбөрийг хэрхэх, энэ нь сангаас өөрөөс нь гарах тохиолдолд захиргааны зардлыг нэмэгдүүлнэ. Тиймээс захиргааны зардлыг өгөөжийн тодорхой хувиар хязгаарлах биш, ХОМК, кастодианы адилаар нийт удирдаж буй хөрөнгийн тодорхой хувь болгож тогтоох нь зөв байна. Энд нийт тэтгэврийн хөрөнгийн 2 хувь байх болов уу.

ЗУРГАА. КАСТОДИАН БАНК, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР:
(Хуулийн төслийн 4-р бүлэг)

- 6.1. “17.1.-д заасан “Хувийн тэтгэврийн сан болон түүний хамаарал бүхий этгээд нь кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлж болохгүй.” гэсний кастодиан гэдгийг хасах. Учир нь кастодиан нь хөрөнгө оруулалтын менежмент зөв хийгдэж байгаа эсэхэд хяналт тавьж хөрөнгө оруулагчийн хөрөнгийг найдвартай хадгалдаг газар тул Хувийн тэтгэврийн сантай хамаарал бүхий этгээд байхад харшлах зүйлгүй, зорилго, ашиг сонирхол нэгтэй, аль аль нь ХОМК-д хяналт тавина. Монгол улсад 3 кастодиан байдаг тул Хөрөнгө оруулалтын менежмент, хувийн тэтгэврийн сан, кастодиан гурвуулаа хамааралгүй байх нь тохиромжгүй. Мөн кастодиан банк болон хөрөнгө оруулалтын менежментийн компани нь шаардлага өндөртэй, СЗХ-ны хатуу хяналтан дор үйл ажиллагаа эрхэлдэг. ХТС-ийн хамаарал бүхий этгээд кастодиан банктай холбоотой байлаа гээд кастодиан банкны үйл ажиллагаанд нөлөөлөх боломжгүй юм.
- 6.2. “18.1.Тэтгэврийн хөрөнгөд кастодианы үйлчилгээ үзүүлэх кастодианыг Хувийн тэтгэврийн сан нь томилох ба түүнд тэтгэврийн хөрөнгийн кастодианы үйл ажиллагааг хариуцуулж кастодианы үйлчилгээний гэрээ байгуулна.” Гэснийг “18.1 Хувийн тэтгэврийн сан нь үйлчлүүлэх кастодианыг **сонгож тэтгэврийн сангийн хөрөнгийг хадгалуулна.**” гэж өөрчлөх. *Кастодианд тэтгэврийн сангийн хөрөнгийг хадгалуулхад гэрээ байгуулж, гэрээгээр үйл ажиллагааг зохицуулах тул хуулинд нэмэлт тайлбарууд оруулах шаардлагагүй.*
- 6.3. “18.8.1.Тэтгэврийн хөрөнгийг бүрдүүлэх нийт үнэт цаасны хадгаламжийн бичгийг хадгалах...” гэснийг “тэтгэврийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийсэн **хөрөнгийн бүртгэлийг хадгалах**” гэж өөрчлөх.
- 6.4. “18.6.3.Хувийн тэтгэврийн сангийн хөрөнгөтэй холбоотой худалдан авах, борлуулах, бусад хэлцэл нь энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон Хувийн тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын бодлогод нийцэж байгаа эсэхэд хяналт тавих; Кастодиан банк нь ХТС-ийн хөрөнгө оруулалтаас орж ирж байгаа орлогоос хуульд заасны дагуу холбогдох **татвар, суутгалыг** тооцон хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг тооцоолдог тул тэтгэврийн хөрөнгөөр хийсэн хөрөнгө оруулалтад татвар суутгалыг ноогдох эсэхийг тодорхой зааж оруулах.
- 6.5. “19.1.Тэтгэврийн хөрөнгөөр зөвхөн энэ хуульд заасан нөхцлийн дагуу, шимтгэл төлөгч, эрх залгамжлагчид, өвлөгчдийн эрх ашгийн үүднээс хөрөнгө оруулалтын орлогыг өсгөх зорилгоор хөрөнгө оруулалт хийнэ. Тэтгэврийн хөрөнгөөр оновчтой хөрөнгө оруулалт хийх нь дараах зорилготой байна: гэснийг “19.1.Тэтгэврийн хөрөнгөөр зөвхөн энэ хуульд заасан нөхцлийн дагуу, шимтгэл төлөгч, эрх залгамжлагчид, өвлөгчдийн эрх ашгийн үүднээс тэдний хуримтлалын **үнэ цэнийг хадгалах, өсгөх зорилгоор** хөрөнгө оруулалт хийнэ. Тэтгэврийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийхэд дараах зарчмыг баримтлана.” гэж өөрчлөх.
- 6.6. “20.1.Хувийн тэтгэврийн сан нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан хөрөнгө оруулалтын менежментийн компанитай хамтран ажиллаж болно...” гэснийг “20.1.Хувийн тэтгэврийн сан нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44

дүгээр зүйлд заасан хөрөнгө оруулалтын менежментийн компанитай **Удирдах зөвлөлөөс зөвшөөрсөн тодорхой хөрөнгийг удирдуулахаар** хамтран ажиллаж болно.” гэж өөрчлөх.

ДОЛОО. ХУВИЙН ТЭТГЭВРИЙН САН ХООРОНД ШИЛЖИХ, ТЭТГЭВРИЙН ДАНС СОЛИХ:

(Хуулийн төслийн 6-р бүлэг, 24, 25 дугаар зүйл)

- 7.1. “24.2-т “Энэ хуулийн дагуу шимтгэл төлөгч өөрийн хүсэлтээр ХТС-г солих, ХТС хооронд шилжиж болно.” гэж орсныг хугацааны хувьд хязгаарлалтайгаар шилжиж болохоор зохицуулах (3 жил дотроо шилжихгүй байх. Гишүүдийн хөдөлгөөн хэт их тохиолдолд ХТС нь үйл ажиллагаагаа тогтвортой төлөвлөж, тогтвортой ажиллах боломжгүй болно.)
- 7.2. “24.7-д шимтгэл төлөгч нь шилжиж буй ХТС-ийн талаар ажил олгогчид болон НДЕГ-т мэдэгдэнэ гэж нэмэх.
- 7.3. ХТС-н үйл ажиллагааг дуусгавар болгохтой холбоотой 25.9.-д зааснаар бүх өр төлбөрийг барагдуулсны дараа ХТС-д хөрөнгө үлдсэн бол шимтгэл төлөгчид хуваарилах бус хувьцаа эзэмшигчдэд олгох гэж өөрчлөх. Бүх өр төлбөр барагдсан гэдгээр шимтгэл төлөгчид хамаарах хөрөнгө бүрэн хуваарилагдсан гэж ойлгогдож байгаа тул үлдэж буй хөрөнгө нь хувьцаа эзэмшигчдэд очих нь зүйтэй гэж үзэж байна.

НАЙМ. БУСАД

- 8.1. Хуулийн төслийн 10.5 дугаар зүйлд заасан **Орон сууц** тэтгэврийн хуримтлалаас худалдан авах боломжийн хувь хэмжээ болон хязгаарыг дараах байдлаар өөрчлөх саналтай байна:
- “10.5. Шимтгэл төлөгч нь насанд хүрсэнээсээ хойш анх удаа өөрийн нэр дээр орон сууц худалдан авах бол шимтгэл төлөгч нь өөрөө тэтгэврийн нэрийн дансанд хуримтлагдсан тэтгэврийн хөрөнгийн 30 хүртэл хувийг зарцуулах хүсэлт гаргаж болно.” гэснийг “анх удаа гэснийг **“1 удаа”**, “30 хүртэл хувийг” гэснийг **“50 хүртэл хувийг”** болгож гэж өөрчлөх саналтай байна.
- Учир нь Монгол хүний дундаж наслалт бага, цаашид өндөр насны тэтгэвэрт гарах нас нэмэгдэнэ. Иймээс шимтгэл төлөгч амьд үедээ хувийн тэтгэврээ өөрт үр ашигтайгаар зарцуулах магадлал бага болж байна. Энэ талаар Сингапурын хувийн тэтгэвэр төлөгчид амьд ахуйдаа тэтгэврийн үр шимээ маш бага хүртэж, харин өвлөгчид очих өв хөрөнгө их болж байгаа муу туршлага бий. Иймд хэдийгээр өөрийн нэр дээр орон сууцтай байсан ч орон сууцаа томруулах, сайжруулах, нэмж орон сууц авах 1 удаагийн боломжийг иргэн бүрт нээх нь зөв гэж үзэж байна.*
